



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ**

2018 оны 04 сарын 03 өдөр

Дугаар 69

Улаанбаатар хот

**Үндсэн хөрөнгө дуудлагын худалдаагаар  
худалдах зөвшөөрөл олгох тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 29 дүгээр зүйл, 31 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2016 оны 128 дугаар тогтоолын 5.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Эрчим хүчний зохицуулах хорооны үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, ашиглалтын хугацаа дууссан, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, цаашид сэргээн засварлах боломжгүй болсон 60,005,240.00 (жаран сая таван мянга хоёр зуун дөчин) төгрөгийн балансын үнэ бүхий автомашиныг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдахыг зөвшөөрч, худалдах доод үнийг хавсралтад заасны дагуу тогтоосугай.

2. Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга З.Мэндсайхан, Эрчим хүчний зохицуулах хорооны дарга А.Тлейхан нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг худалдах ажлыг холбогдох хууль тогтоомж, захиргааны актын дагуу зохион байгуулах;

2.2. Дуудлагын худалдаанаас олох орлогыг зохих захиргааны актын дагуу улсын төсөвт төвлөрүүлэх;

2.3. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.4. Энэ тогтоолын биелэлтийг 2018 оны 2 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГА


ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН ХЭЛТСИЙН  
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Ц.НЯМ-ОСОР

Э.ЭРДЭНЭХИШИГ

0001529

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2018 оны 04 дүгээр сарын 03 -ны өдрийн  
6.9 дугаар тогтоолын хавсралт



**Эрчим хүчний зохицуулах хорооны үндсэн хөрөнгөд бүртгэлтэй,  
нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах автомашины жагсаалт**

| Д/д | Автомашины марк, улсын дугаар, зориулалт, хөдөлгүүр, арлын дугаар       | Үйлдвэр лэсэн/ ашиглалтад орсон он | Нийт гүйлт /км/ | Балансын үнэ /төгрөг/   | Хуримтлагдсан элэгдэл /төгрөг/                                  | Үлдэх өртөг /төгрөг/ | Сэргээн босголтын зардал /төгрөг/ | Худалдах доод үнэ /төгрөг/          |
|-----|---|------------------------------------|-----------------|---|---|----------------------|-----------------------------------|-------------------------------------|
| 1   | "Хьюндай Санта фе", 99-52 УНМ, суудлын, G4KEBU330529, КМНШН31BDBU747118 | 2011/2011                          | 104000          | 34,990,000.00   | 34,990,000.00   | 0                    | 0                                 | 4,000,000.00                        |
| 2   | "Хьюндай Соната NF", 20-63 УБЗ, суудлын, G4KO8855652, КМНЕТ41АР9А557288 | 2008/2008                          | 129500          | 25,015,240.00   | 25,015,240.00   | 0                    | 0                                 | 3,000,000.00                        |
|     | <b>Нийт дүн</b>   |                                    |                 | <b>60,005,240.00</b><br>(жаран сая таван мянга хоёр зуун дөчин) | <b>60,005,240.00</b><br>(жаран сая таван мянга хоёр зуун дөчин) | -                    | -                                 | <b>7,000,000.00</b><br>(долоон сая) |